



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 01 дугаар сарын 24

№ 03/09

Улаанбаатар хот

Г АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ ТАНАА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.11, 18 дугаар зүйлийн 18.1.1, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтыг хорооны ажлын алба, бусад байгууллагын төлөөлөлтэй уулзаж, хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тайлбар авах, хүүхэд хамгааллын байгууллагын үйл ажиллагаа, байрны нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, баримтжуулалт хийх, мэдээлэл авах, холбогдох бичиг баримтыг гаргуулан авч дун шинжилгээ хийх зэрэг аргачлалаар явуулсан бөгөөд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/180 дугаар тушаалаар баталсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын 3.10-д “Хууль зүйн хорооны гишүүн энэ журмын 3.9-д заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна Хууль зүйн хороо, Ажлын албаны үйл ажиллагаанд энэ журмын 3.11-3.22 дахь хэсэгт зааснаар оролцно” гэж заасан. Гэвч тус хяналт шалгалтын үеэр Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны төлөөлөл болох Шүүхийн Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэрэгжүүлсэн ажлын мэдээллээ ирүүлээгүй, Цагдаагийн болон Прокурорын газар нь зөвхөн гэмт хэргийн бүртгэл ирүүлж, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын мэдээллээ ирүүлээгүй нь хорооны гишүүдийн оролцоо сул, холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэх байдал болон байгууллага хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй байгааг илтгэж байна.

2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.10 дахь заалтад “Хууль зүйн хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдана” гэж заасан байх боловч аймгийн Хүүхдийн хууль эрх зүйн хороо нь 2022 оны төлөвлөгөө батлах болон бусад үйл ажиллагааны чиглэлээр 2 удаа хуралдсан байна.

3. Хяналт шалгалтын үеэр хорооноос үйлчилгээ авч байгаа хүүхэд бурийг оршин суух сум, хорооны хамтарсан багт шилжүүлдэг гэсэн тайлбарыг өгч байсан боловч хамтарсан багтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллаагүй байна. Иймд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын 5 дугаар зүйлийн 5.7 дахь заалтад заасан “Ажлын албанаас үйлчилгээ авч буй хүүхдийн оршин суух сум, хорооны хамтарсан баг, бусад талтай хамтран төлөвлөгөө


гарган ажиллаж болно” гэсний дагуу төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллах шаардлагатай байна.

Дээрх хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт холбоотой кэйс гарах бүрт хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь тухай бүр хуралдаж, хорооны гишүүдийн ажил үүргийн хүрээнд төлөвлөгөө гарган оролцоо, хамтын ажиллагааг сайжруулж, чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах;
2. Хүүхэд дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, үр дүнтэй нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах;
3. Хорооноос үйлчилгээ авч байгаа хүүхэд бүрийн оршин суугаа сумын хамтарсан багтай төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж хамтран ажиллах;
4. Гэмт хэрэгт холбогдсон болон гэрч, хохирогч хүүхдүүдээс тайлбар мэдээлэл аваадаа Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг энгийн хувцастай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан бөгөөд зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн талаар нотлох баримтын хамт мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Х.МОНХЗУЛ